



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

06/06 оны 09 сарын 22-ны өдөр

Дугаар A/98

Эрдэнэт

Хуваарь батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.14, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Эх хүүхэд, нөхөн үржихүүн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр, ЭМС-ын 2017 оны "Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлах тухай" A/129 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах БОЭТ-ийн нярай, хүүхдийн эмч нарын хуваарийг 1-р хавсралтаар, ажиллах журмыг 2-р хавсралтаар, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нярай, хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээний багцыг 3-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуваарийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг мэргэжил арга зүйгээр ханган уялдаа холбоотой хамтарч ажиллахыг БОЭТ-ийн нярай, хүүхдийн эмч нар, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд мөрдүүлж, үр дүнг тооцон ажиллахыг Хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /П.Хишгээ/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
09. сарын 29 өдрийн 17:00 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжил арга зүйгээр хангаж
ажиллах БОЭТ-ийн нярай, хүүхдийн эмчийн хуваарь

№	ӨЭМТ-н нэр			Хариуцах нярайн эмчийн нэр	Хариуцах хүүхдийн эмчийн нэр
1	Үйлсбадрах	2	Нийцэл	БОЭТ-ийн нярайн эмч М.Баттуяа	БОЭТ-ийн хүүхдийн эмч Д.Цогзолмаа
3	Учралтбаяр	4	Мөнхийн гэгээ	БОЭТ-ийн нярайн тасгийн эрхлэгч Ч.Болор	БОЭТ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч М.Уртнасан
5	Мэндсэцэн	6	Энхжихмандариваа	БОЭТ-ийн нярайн эмч Б.Гантуяа	БОЭТ-ийн хүүхдийн эмч Б.Номин
7	Анхны оч	8	Мөнхсүндэрэл	БОЭТ-ийн нярайн эмч А.Намжилмаа	БОЭТ-ийн хүүхдийн эмч Ц.Энхтуяа
9	Жаргалант СЭМТ			БОЭТ-ийн амбулаторийн эмч Ц.Бямбажав	БОЭТ-ийн хүүхдийн эмч О.Оргилбаатар

60-43446 2020030026

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг мэргэжилт арга зүйгээр хангаж ажиллах нярай,
хүүхдийн эмч нарын журам

1. Нярай болон хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэгжиж байгаа стандарт,эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн зөвлөмжийг сар тутамд өгөх
2. Нярай болон хүүхдийн биед үзлэг хийх, эрхтэн тогтолцооны эмгэг болон суурь өвчнийг илрүүлэхэд анхаарах асуудлаар улирал тутамд хуваарилагдсан сум,өрхийн эрүүл мэндийн төвийн эмч,эмнэлгийн мэргэжилтэнд зөвлөгөө өгөх
3. Нярай болон хүүхдийн биеийн байдлыг ХӨЦМ-ээр үнэлэх, эрэмбэлэн ангилж, эмнэлгийн болон яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдал,эм эмнэлгийн хэрэгслийн хангарт, ашиглалтын байдалд зөвлөгөө өгөх
4. Эрүүл хүүхдийн өсөлт хөгжлийг үнэлэх, асаргаа, хооллолт, урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх эмч,эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах
5. Эх хүүхдийн дэвтэр, бага насны хүүхдийн хооллолт, өсөлт хөгжлийг үнэлэх анхан шатны маятуудыг зөв, бүрэн хөтлөхөд зөвлөгөө өгөх
6. Бага жинтэй төрсөн нярайн хооллолт,асаргааны онцлог, өвчтэй хүүхдийн биеийн байдлыг үнэлэх, зонхилон тохиолдох эмгэгийг эрт илрүүлэх, эмчилгээ, идэвхтэй хяналт, асаргаа сувилгааны чиглэлээр эцэг эхэд зөвлөх ур чадварт суралцуулах сургалтыг зохион байгуулах
7. Өрхийн эмч,эмнэлгийн мэргэжилтнүүд болон эцэг эх асран хамгаалагчдад сургалт явуулах
8. Бага насны хүүхдийн болон өсвөр үе, зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн үзлэгийг хамтран зохион байгуулах
9. БОЭТ-ийн нярай, хүүхдийн тасгийн хүлээн авах хэсгийн ачааллыг бууруулах зорилгоор хуваарилагдсан сум,өрхийн эрүүл мэндийн төвөөс онош тодруулахаар БОЭТ-ийн нярай,хүүхдийн тасагт илгээсэн хүүхдийг үзэх, үнэлэх, зөвлөгөө өгөх
10. Нярай болон хүүхэд,өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлаар санал гаргах, хамтарсан судалгаа хийх
11. Амьсгалын замын халдварт өвчин ,ТТӨ, Ковид-19-ын дэгдэлтийн үеийн тусламж үйлчилгээний ачаалалыг бууруулахад чиглэсэн холбогдох зохицуулалт хийх,эмнэлзүйн удирдамж,тушаал зааврын хэрэгжилтэнд Эрүүл мэндийн газартай хамтран үнэлгээ, дүгнэлт гаргах

Эрүүл мэндийн газрын даргын ~~2020~~ оны
19 сарын 18... өдрийн 118 дугаар тушаалын
3 дугаар хавсралт



Хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээний багц

Үндсэн багц	Тусlamж үйлчилгээний жагсаалт	Өрхийн эрүүл мэндийн төв				
		Үрьдчилсан саадлыг х оношлох	Хянах	Илгээх	Эмчлэх	Холбоо
1.1.1. Нярай хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ						
Эрүүл нярай хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	Гэрээр эргэх	✓			✓	
	Нярайн асаргаа, сувилгаа, зөвлөгөө өгөх	✓			✓	
	Аминдэмийг сэргийлэх тунгаар өгөх	✓	✓	✓	✓	✓
	Товлолт болон нөхөн дархлаажуулалтанд хамруулах	✓			✓	
	Өсөлт хөгжлийг үнэлэх	✓	✓	✓	✓	✓
Өвчтэй болон эрхтэн тогтолцооны эмгэгтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	Шарлалттай нярайд тусlamж үзүүлэх	✓	✓	✓	✓	✓
	Хооллолтын бэрхшээлтэй, бага жинтэй нярайд тусlamж үзүүлэх	✓	✓	✓	✓	✓
	Суулгалттай нярайд тусlamж үзүүлэх	✓	✓	✓	✓	✓
	Арьсны идээт тууралттай, нянгийн халдвартай нярайд тусlamж үзүүлэх	✓	✓	✓	✓	✓
	Хатгаатай нярайд тусlamж үзүүлэх	✓	✓	✓	✓	✓
	Аюултай болон тулгамдсан шинж илэрсэн нярайд тусlamж үзүүлэх		✓	✓*		✓
1.1.2. 2 сартайгаас 5 хүртэлх насны хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ						
Эрүүл хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	Гэрээр эргэх	✓			✓	
	Хүүхдийн асаргаа, сувилгаа, зөвлөгөө өгөх	✓			✓	
	Аминдэмийг сэргийлэх тунгаар өгөх	✓			✓	
	Хооллолтыг үнэлэх	✓	✓	✓	✓	✓
	Товлолт болон нөхөн дархлаажуулалтанд хамруулах	✓			✓	
	Өсөлт хөгжлийг үнэлэх	✓	✓	✓	✓	✓
	Нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	✓				
	Тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх	✓				
Өвчтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	Аюултай ерөнхий шинжтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ		✓	✓	✓	✓
	Ханиалгалт ба амьсгалын саадтай үед үзүүлэх тусlamж үйлчилгээ		✓	✓	✓	✓
	Суулгалттай хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ		✓	✓	✓	✓
	Халууралттай хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ		✓	✓	✓	✓
	Чихний өвчтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ		✓	✓	✓	✓

	Суурь өвчтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Хооллолтын бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Бусад эрхтэн тогтолцооны эмгэгтэй хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
1.1.3.Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ						
Өсвөр насны эрүүл хүүхдэд үзүүлэх тусlamж үйлчилгээ	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ	✓		✓	✓	
	Бэлгийн замын халдварын үеийн тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Хорт зуршилаас сэргийлэх, эрт илрүүлэлтийн үеийн тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Сэтгэлзүйн тусlamж үйлчилгээ	✓	✓	✓	✓	✓
	Нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	✓			✓	
	Тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх	✓				

✓*-Гарааны эмчилгээ хийж, яаралтай илгээх